

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Хүн Амын Сургалт Судалгааны Төв, Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгтэй хамтран “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 24 дах дугаараа бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн энэ дугаарын **“Судалгаа”** хэсэгт Монгол улсын хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхийн дундаж хугацаа: олон шатат өргөтгөсөн насжилтын хүснэгт ашиглан тооцсон үр дүнг танилцуулж байна. Хүн амын ядуурлыг зөвхөн орлого/хэрэглээгээр хэмжих бус нийгэм-эдийн засгийн олон талаас нь харж, оновчтой тогтоох боломжууд байгааг Ядуурлыг олон хэмжээсээр үнэлэх нь судалгааны ажлаас олж уншаарай. Сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газраас нийгмийн хамгаалалд зарцуулж буй хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн хэдий ч зорилтод бүлэгт хүрч чадахгүй байгааг нотолсон тооцооллын үр дүнг Нийгмийн хамгааллын индексийн тооцоолол сэдэвт судалгааны ажлаас харж болно. Түүнчлэн, энэ дугаартаа бид Монгол дах гэрлэгсдийн боловсролын ижил төстэй байдал, Булган аймгийн Сэлэнгэ сумын төвийн ерөнхий төлөвлөгөө зэрэг эрдэм шинжилгээний ажлуудаас гарсан үр дүн, санал зөвлөмжийг танилцуулж байна.

“Сургалт” хэсгээс “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга, аргачлал”-ийн талаар шинэ мэдлэг олж, оюуны цар хүрээгээ тэлээрэй. Хөгжлийн аливаа бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг хянах, үр дүнг үнэлэхэд энэхүү сургалт таньд тус нэмэр болно гэдэгт бид итгэлтэй байна.

Сэтгүүлийнхээ **English** хэсэгт гэр хорооллын усан хангамжийн хүртээмжийн нөхцөл байдлыг Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Баянхошуу орчмын гэр хорооллын жишээн дээр гүнзгийрүүлэн шинжилж, үр дүнг танилцуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон уг сэтгүүлийн энэ дугаарыг бэлтгэн хэвлэхэд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монгол Улсын Их Сургуульд сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ